



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/489

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд Хөшөөт хөгжил сангийн 2018 оны үлдэгдэл хөрөнгөөс 8 743 255 төгрөг /Найман сая долоон зуун дөчин гурван мянга хоёр зуун тавин таван/-ийг Ховд аймгийн Жаргалант сумын төв дөрвөн замын уулзварын гэрлэн дохионы кабель солих ажлын санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу зарцуулсугай.

2.Дээрх төсөл арга хэмжээнд зарцуулагдах 8 743 255 төгрөг /Найман сая долоон зуун дөчин гурван мянга хоёр зуун тавин тав/-ийг санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ